



Co-funded by
the European Union



Estonian University
of Life Sciences

MICROCREDENTIALS FOR UKRAINE AND MONGOLIA

Università
di Catania



NAKA
Estonian Quality
Agency for Education



“МОНГОЛЫН УЛСЫН ЗЭРГИЙН БУС СУРГАЛТЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, БЭРХШЭЭЛ, БОЛОМЖ, ЦААШДЫН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Огноо: 2025 оны 05 сарын 06 өдөр

Эхлэх цаг: 12:30

Арга хэмжээ: Цахим болон танхим хосолсон нээлттэй хэлэлцүүлэг

Цахим хандалт: *A link for online participation will be created.*


Байршил: МУИС-ийн Ном сангийн байрны 502 тоот танхим

Газрын зураг: QR код → Гүүглэ газрын зураг дээр байршил олно уу

Хэл: Монгол хэл/ Англи хэлээрх илтгэл орчуулгатай.

Оролцогчид: Их, дээд боловсролын байгууллагууд
Төслийн хамтрагч байгууллагууд (Европ болон Монгол)
Төрийн болон төрийн бус байгууллагууд
Ажил олгогчид
Олон улсын болон үндэсний зөвлөхүүд
Насан туршийн болон мэргэжлийн боловсролын байгууллагууд
Зэргийн бус сургалтад хамрагдагчид

Хөтлөгч: О.Алтансүх, DOMANI төслийн үндэсний зохицуулагч



Зорилго: Их, дээд сургуулийн зэргийн бус (микро кредит - бичил кредит) сургалтын үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, тулгарч буй саад бэрхшээлийг тодруулах, ямар боломж байгааг илрүүлэх, түүнийг зүй зохистой хөгжүүлэхийн тулд баримтлах төлөвлөгөө, дүрэм журам, стандартад тусгавал зохих асуудлыг тодорхойлоход оршино. Уг зорилгоо хангахын тулд сонирхогч талуудын оролцоог хангах, тэднийг санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг нээх, үнэтэй санал, зөвлөмжийг цаашдын үйл ажиллагаандаа тусгах, талуудын хамтын ажиллагааг дэмжихийн зэрэгцээ Монгол болон Европын Холбооны туршлагын тухай оролцогчдод таниулна.

Төсөөлж буй үр дүн:

- Оролцогчид зэргийн бус бичил сургалтын хөтөлбөрийн Европын Холбооны шилдэг туршлага, бодлого, стратеги, загваруудын тухай, мөн насан туршийн суралцахуй болон ажиллах хүчний хөгжилд зэргийн бус бичил сургалтын гүйцэтгэх үүргийн талаар тодорхой ойлголттой болно.
- Монгол Улсын зэргийн бус бичил сургалт явуулах өнөөгийн нөхцөл байдал, шаардлагатай буюу дутагдаж байгаа зүйлс, тулгарч буй сорилт бэрхшээл, боломжуудыг тодорхойлох, дээд боловсрол болон мэргэжлийн сургалтад зэргийн бус бичил сургалтыг нэвтрүүлэх замын зураглал гаргана.
- Их сургууль, аж үйлдвэрийн салбар, төрийн байгууллага хоорондын түншлэлийг бэхжүүлнэ.
- Зэргийн бус (бичил кредит) сургалтын үндэсний болон дотоод журмын төсөл боловсруулахад шаардлагатай саналууд цуглуулна.

Хөтөлбөр:

Хугацаа	Сэдэв	Илтгэгч
12:30-13:00	Бүртгэл	Б.Отгонбат
13:00-13:10	Нээлт, мэндчилгээ	Д.Заяабаатар Сургалт, оюутны хөгжил хариуцсан проректор
13:10-13:25	DOMANI төслийн танилцуулга Хэлэлцүүлгийн зорилго ба хүлээлт	О.Алтансүх DOMANI үндэсний зохицуулагч
ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ		
13:25-13:40	МУИС-ийн зэргийн бус сургалтын өнөөгийн тогтолцоо, цаашдын бодлого	С.Булгантамир Сургалтын хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын газрын дарга
13:40-13:55	ШУТИС-ийн зэргийн бус сургалтын өнөөгийн тогтолцоо, цаашдын бодлого	Д.Гэрэлт-Од ШУТИС-ийн ГУУС-ийн Эрдэс боловсруулалт, инженерчлэлийн салбарын эрхлэгч
13:55-14:10	Мэргэжлийн болон техникийн боловсрол, чадамжийн гэрчилгээ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Сургалт, Үнэлгээ, Судалгааны Институт
14:10-14:25	Дээд боловсролын байгууллагатай хамтран микро кредитийн сургалтаар үндэсний мэргэжилтэн бэлтгэж буй туршлага: Байгаль орчны аудиторовын сургалт	Т.Индра Байгаль орчны аудитын холбооны Удирдах зөвлөлийн дарга
БЭРХШЭЭЛ болон БОЛОМЖ		
14:25-14:50	Микро кредитын сургалт дахь Европын туршлага - Бодлого - Магадлан итгэмжлэл - Эстони улсын жишээ	Кристина Марран /цахим/ Эстонийн ХААИС-ийн Нээлттэй их сургуулийн захирал DOMANI зохицуулагч Н.Оюунчимэг - Орчуулгач
14:50-15:15	Микро кредитын сургалт дахь Европын туршлага - ЖДҮ, бизнес эрхлэгчдэд зориулсан сургалт - Итгэмжлэлийн механизм	Аттила Катона /цахим/ Системийн инновацийн төвийн дарга Н.Оюунчимэг - Орчуулгач
15:15-15:30	Монгол Улсын зэргийн бус бичил сургалтын өнөөгийн байдал, бэрхшээл, боломж	П.Содгэрэл ХААИС-ийн Агроэкологи, бизнесийн сургууль
15:30-15:55	Өнөөгийн нөхцөл байдал, сорилт, боломжуудын талаар дугуй ширээний хэлэлцүүлэг <i>Оролцогчид бүлгүүдэд хуваагдаж, санал бодлоо илэрхийлнэ.</i>	О.Алтансүх Хөтлөгч
15:55-16:00	Хэлэлцүүлэгт оролцогчдын фото зураг	
16:00-16:20	Кофе, цайны завсарлага	
ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА		
16:20-16:35	Зэргийн бус бичил сургалтыг магадлан итгэмжлэх, албан ёсоор хүлээн зөвшөөрөх үйл явц	Б.Басбаяр Монголын боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
16:35-16:50	Монгол улсын зэргийн бус сургалтын экосистем: дээд боловсролын салбарын мэргэжилтэн бэлтгэх стратеги, бодлого, практик	Ц.Бурмаа ХААИС-ийн Агроэкологи, бизнесийн сургуулийн ЭНДБ
16:50-17:20	Зэргийн бус боловсролын цаашдын хөгжлийн талаар нээлттэй хэлэлцүүлэг <i>Оролцогчид гараа өргөж, санал бодлоо чөлөөтэй илэрхийлнэ.</i>	О.Алтансүх Хөтлөгч
17:20-17:30	Дүгнэлт ба хаалтын үг - Хэлэлцүүлгийн гол санааг тоймлох - Дээд боловсролын байгууллагын зэргийн бус сургалтын хөгжлийн боломж	С.Булгантамир Сургалтын хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын газрын дарга